

МЭРГЭШҮҮЛЭХ ДИПЛОМЫН СУРГАЛТЫН ТӨГСӨЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар Удирдлагын Академийн Төрийн алба, удирдлагын сургуулийн төр, бизнес, нийгмийн удирдлагаар мэргэшүүлэх дипломын сургалтад суралцаж хичээлийн багц цагийг бүрэн биелүүлсэн суралцагчдаас төгсөлтийн шалгалт авах, бүлгийн судалгаа хийлгэж, хамгаалуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Сургалтын төлөвлөгөөний дагуу шаардлагатай багц цагийг бүрэн биелүүлж, бүлгийн судалгаа хийж, судалгааны тайлангаа амжилттай хамгаалсан буюу төгсөлтийн шалгалтад амжилттай шалгагдсан суралцагчдад мэргэшлийн диплом олгож төгсгөнө.
- 1.3 Бүлгийн судалгааны тайлан хамгаалуулах, төгсөлтийн шалгалт авах ажиллагааг Төрийн алба, удирдлагын сургуулийн захирлын тушаалаар томилсон комисс зохион байгуулж дүгнэнэ.

Хоёр. Бүлгийн судалгаа

- 2.1 Бүлгийн судалгааны сэдвийг Удирдлагын Академи, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, тэнхим, профессорын баг, багш нарын судалгааны чиглэл, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн захиалгат судалгаатай уялдуулан тогтооно.
- 2.2 Бүлгийн судалгаа хийлгэх чиглэл, сэдвийн талаарх саналаа хүрээлэн, тэнхим, профессорын багууд хэлэлцэн хичээлийн жилийн эхэнд буюу жил бүрийн есдүгээр сард багтаан Төрийн алба, удирдлагын сургуульд ирүүлнэ. Саналд судалгааны үндэслэл, хамрах хүрээ, үргэлжлэх хугацааг заасан байна.
- 2.3 Суралцсан хугацаандаа 3.5 ба түүнээс дээш голч дүнтэй суралцсан, хичээлийн 8-аас доошгүй багц цаг биелүүлсэн, “Судалгааны арга зүйн үндэс”, “Судалгааны бичлэг, илтгэх ур чадвар” хичээлээр В+-ээс доошгүй үнэлгээтэй, судалгааны арга зүй эзэмшсэн, судалгаа хийх сонирхолтой суралцагчид холбогдох хөтөлбөрийнхөө дагуу бүлгийн судалгаа хийх эрхтэй.
- 2.4 Бүлгийн бүрэлдэхүүн, судалгааны сэдвийг Төрийн алба, удирдлагын сургуулийн захирал батална.
- 2.5 Мэргэшүүлэх дипломын сургалтын төгсөлт бүрт мэргэшлийн хөтөлбөр тус бүрээр 3-аас илүүгүй судалгааны бүлэг байгуулна. Судалгааны бүлэг нь 3-5 гишүүнтэй байна. Удирдагч багш, зөвлөх багшийг Төрийн алба, удирдлагын сургуулийн захирлын тушаалаар томилно.
- 2.6 Удирдагч багш нь судалгааны ажлыг удирдах ба судалгааны ажлын удирдамж, судалгааны тайлангийн агуулгыг батлах, ажлыг нь чиглүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих, мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, Академийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандартыг мөрдүүлэх, зааварчилгаа өгөх үүрэгтэй байна.
- 2.7 Зөвлөх багш нь судалгааны ажлын явцад онол, арга зүйн зөвлөгөө өгөх, судалгааны тайланд үнэлгээ хийх үүрэгтэй бөгөөд судалгааны тайлан хамгаалуулах комисст өөрийн санал, үнэлгээг бичгээр ирүүлнэ.

- 2.8 Бүлгийн судалгааг үнэлж дүгнэх үйл явц нь хоёр үе шаттай байна. Үүнд:
- 2.8.1 Судалгааны тайлангийн хэлэлцүүлэг
 - 2.8.2 Судалгааны тайлан хамгаалалт
- 2.9 Судалгааны бүлэг нь төгсөх улирлын шалгалтын долоо хоногт судалгааны тайланг бичиж дуусгана.
- 2.10 Судалгааны тайланг Төрийн алба, удирдлагын сургуулийн захирлын тушаалаар томилогдсон гурван гишүүний бүрэлдэхүүнтэй комиссоор хэлэлцүүлнэ. Комиссын бүрэлдэхүүнд судалгааны зөвлөх багшаас гадна тухайн мэргэшлийн чиглэлийн профессор, багш нарын төлөөлөл орно.
- 2.11 Судалгааны бүлэг нь тайлангаа хэлэлцүүлэг болохоос хоёр хоногийн өмнө комиссын гишүүдэд хүлээлгэж өгнө. Комиссын гишүүд судалгааны тайлантай танилцаж саналаа бэлтгэсэн байна.
- 2.12 Бүлгийн судалгааны хэлэлцүүлэг дээр судалгааны бүлэг нь судалгааны арга, аргачлал, явц, үр дүн, тайлангийн агуулгын талаар илтгэж танилцуулна. Комисс нь судалгааны үр дүн, зорилгодоо хүрсэн байдал, судалгааны тайлангийн бичилтийг үндэслэн судалгааны ажлыг хамгаалалтад оруулах эсэхийг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хамгаалалтад оруулахаас татгалзвал, үндэслэлээ Төрийн алба, удирдлагын сургуульд бичгээр ирүүлнэ.
- 2.13 Судалгааны тайлангийн хэлэлцүүлгээс гаргасан шийдвэр, санал, зөвлөмжийг Хэлэлцүүлгийн тэмдэглэл (Маягт БС-1)-д бичиж, Төрийн алба, удирдлагын сургуульд ирүүлнэ.
- 2.14 Хамгаалалтад орох зөвшөөрөл авсан судалгааны бүлэг нь хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийн дагуу судалгааны тайланг эцэслэн боловсруулж, хамгаалалт болохоос хоёр хоногийн өмнө комиссын гишүүдэд хүлээлгэж өгнө.
- 2.15 Судалгааны тайлангаа хамгаалж чадаагүй бүлэг цаашид судалгаагаа үргэлжлүүлэн хийж, дараагийн улиралд тайлангаа бичиж дуусган дахин хэлэлцүүлж болно. Судалгааны бүлэг судалгааг цаашид үргэлжлүүлэн хийхээс татгалзвал дараагийн улиралд Ерөнхий ур чадвар олгох хичээлээс сонгон үлдсэн багц цагаа биелүүлж, төгсөлтийн шалгалт өгнө.
- 2.16 Хамгаалалтыг тухайн судалгааны тайлангийн хэлэлцүүлэг болсоноос хойш арван хоногийн дараа явуулна.
- 2.17 Хамгаалалтаар судалгааны бүлэг нь судалгааны зорилго, зорилт, арга зүй, хамарсан хүрээ, ач холбогдол, судалгааны үр дүн, гаргасан санал, зөвлөмжийг нэгтгэн 10 минутад багтаан товч илтгэнэ. Үүний дараа судалгаа, тайлан, илтгэлтэй холбоотой асуулт, хариулт явуулж, зөвлөх багшийн ирүүлсэн саналыг сонсоно.
- 2.18 Хамгаалуулах комиссын гишүүд судалгааны үр дүн, тайланг хэлэлцэж, саналаа солилцоод Үнэлгээний хуудас (Маягт БС-2)-ын дагуу бүлгийн судалгааг дүгнэнэ. “Удирдлагын Академийн сургалтад багц цаг тооцох, суралцагчдын мэдлэг чадварыг үнэлж дүгнэх журам”-ын дагуу комиссын гишүүн бүрийн үнэлгээний арифметик дунджаар (Маягт БС-3) дүнг гаргаж, багц цаг тооцно.
- 2.19 Комисс нь хамгаалалтын дүнг Төрийн алба, удирдлагын сургууль болон Академийн Сургалтын бодлого, зохицуулалтын албанд тухайн өдөрт нь багтаан ирүүлнэ.

Гурав. Төгсөлтийн шалгалт

- 3.1 Төгсөлтийн шалгалтыг хичээлийн жилд дөрвөн удаа буюу мэргэшүүлэх дипломын сургалтын төгсөлт бүрээр зохион байгуулж авна.
- 3.2 Төгсөлтийн шалгалтын хуваарь (өдөр, цаг, танхим, дараалал)-ийг Төрийн алба, удирдлагын сургууль тогтооно. Суралцагч хуваарьт заасан өдөр, цаг, танхимд шалгалтаа өгнө.
- 3.3 Төгсөлтийн шалгалтын комисс нь шалгалтыг шударгаар зохион байгуулах, суралцагчийн мэдлэг чадварыг үнэн зөв, бодитой үнэлж дүгнэх, шалгалтын нууцлалыг чанд сахих үүрэгтэй.
- 3.4 Төгсөлтийн шалгалтын өмнө шалгуулагчдын дүнгийн нэгдсэн жагсаалтыг Академийн Сургалтын бодлого, зохицуулалтын алба гаргаж, комисст ирүүлнэ.
- 3.5 Бүлгийн судалгаа хийхгүй суралцагчид Сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 21 багц цаг биелүүлсний дараа төгсөлтийн шалгалт өгнө.
- 3.6 Төгсөлтийн шалгалт нь сорил, бичгийн шалгалт гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Сорил нь тухайн мэргэшлийн суурь хичээлүүдийн агуулгаар, бичгийн шалгалт нь тухайн суралцагчийн сонгон судалсан мэргэшүүлэх хичээлүүдийн агуулгаар эзэмшсэн мэдлэг чадварын түвшинг тогтоож үнэлэх зорилготой байна.
- 3.7 Сорилын сан, бичгийн шалгалтын асуултыг мэргэжлийн багш нар хичээлүүдийн багцын хүрээнд боловсруулж, Төрийн алба, удирдлагын сургууль дээр төвлөрүүлнэ. Сорилын сан, бичгийн шалгалтын асуултыг хичээлийн жил бүр баяжуулж байна. Сорил болон бичгийн шалгалтын асуултын тоог Төрийн алба, удирдлагын сургууль шалгалт авах бүрт тогтооно.
- 3.8 Суралцагч нь сорилын шалгалтын хариултыг тусгайлан бэлтгэсэн хариултын хүснэгтэд бөглөх ба шалгалтын комисс сорилыг машинаар засаад дүнг гаргаж, Төрийн алба, удирдлагын сургуульд хүргүүлнэ.
- 3.9 Бичгийн шалгалтад суралцагч нь өөрийн сонгож судалсан мэргэшүүлэх хичээлүүдийн агуулгын хүрээнд бэлтгэгдсэн асуултад хариулна. Асуултад хариулахдаа холбогдох онол, арга зүй, практикийн баримт нотолгоо, жишээтэйгээр шинжилгээ хийж, дүгнэж бичнэ. Бичгийн шалгалтыг тухайн мэргэжлийн багш уншиж үнэлгээ өгнө.
- 3.10 Төгсөлтийн шалгалтыг зохион байгуулах зааврыг Төрийн алба, удирдлагын сургуулиас гаргана.
- 3.11 Сорилын ба бичгийн шалгалтын үнэлгээ нь 2:3-ын харьцаатай байна.
- 3.12 Төгсөлтийн шалгалтыг “Удирдлагын Академийн сургалтад багц цаг тооцох, суралцагчдын мэдлэг чадварыг үнэлж дүгнэх журам”-ын дагуу дүгнэж, багц цаг тооцно.
- 3.13 Төгсөлтийн шалгалтад амжилтгүй буюу “F” үнэлгээтэй шалгагдсан суралцагч нь шалгалтаа дахин нэг удаа өгөх эрхтэй. Төгсөлтийн шалгалтад амжилтгүй шалгагдсан буюу шалгалтаа өгөөгүй суралцагчийг дараагийн төгсөлтийн шалгалтад оруулна.
- 3.14 Комисс нь сорилын шалгалтын дүнг тухайн өдөрт нь, бичгийн шалгалтын дүнг хоёр өдөрт багтаан гаргаж, Төрийн алба, удирдлагын сургууль хүргүүлнэ.
- 3.15 Төгсөлтийн шалгалтын нэгдсэн дүнг Төрийн алба, удирдлагын сургууль сорилын болон бичгийн шалгалтын дүнг үндэслэн гаргаж мэдээлэх ба Академийн Сургалтын бодлого, зохицуулалтын албанд тухайн өдөрт нь багтаан хүргүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

- 4.1 Бүлгийн судалгаа, түүний явц, үр дүн, тайлангийн хэлэлцүүлэг, хамгаалалт, төгсөлтийн шалгалтын агуулга, хэлбэр, хуваарь, үр дүнгийн талаарх гомдлыг Төрийн алба, удирдлагын сургуулийн захирлын зөвлөл хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэнэ.
- 4.2 Бүлгийн судалгааны явц, үр дүн, хэлэлцүүлэг, хамгаалалт, комиссын үйл ажиллагаанд Төрийн алба, удирдлагын сургууль, холбогдох мэргэшлийн хөтөлбөр хяналт тавьж ажиллана.
- 4.3 Төгсөлтийн шалгалтын явц, үр дүн, зохион байгуулалт, төв болон салбар комиссын үйл ажиллагаанд Төрийн алба, удирдлагын сургууль, холбогдох тэнхим, мэргэшлийн хөтөлбөрүүд хяналт тавьж ажиллана.